


ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН ТАНИЛЦУУЛГА

1. Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, онцлог:



- Халхын Сэцэн хан аймгийн Дархан хошой Чин дангийн хошуу, Эрдэнэдалай вангийн хошууны нутаг нь 1655-1707 онуудад байгуулагдсан бөгөөд Их эзэн Чингис хааны эх Өэлүн, дүү Отчигон хоёрын нутаглаж бүхий газар хэмээн түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд мөн Хубилай хааны төрсөн нутаг болох талаар түүхийн улбааг эрдэмтэд судлан тогтоохоор ажиллаж байна. Ардын хувьсгал ялсны дараагаар 1923 онд Хан Хэнтий уулын аймагт багтан байгуулагдсан, түүхэндээ 3 удаа томоохон нүүдэл хийж, 1941 онд Хөндлөн Ухаагаас Жавхлантын өвөрт ирж суурьшжээ.
- Тус сум нь 338.1 мян.га газар нутагтай, Дорнодын их талын баруун зах, Хэнтий аймгийн зүүн хилд Батноров, Норовлин, Баянхутаг, Дорнод аймгийн Хөлөнбуйр, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт сумдтай хил залган оршдог.
- Баян-Овоо сум нь Монголын Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Ухаа гүвээт Халхын дундад талын тойрогт хамрагдах бөгөөд хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 830-1400м-т оршдог.
- Нутгийн урд хэсэгт байгалийн үзэсгэлэн цогцолсон, геологийн өвөрмөц тогтоцтой “Хар-Ямаат”-ын БНГ 40.5 мян\га, зүүн хэсэгтээ тал хээрийн экосистемийг бүрдүүлэгч цагаан зээрийн нутаг болох “Тосонхулстай” БНГ 54.9 мян\га нутгийг хамардаг.
- Хар-Ямаатын БНГ-т улиас, улиангаран төгөлтэй, өрөл, мойл, нохойн хошуу, гүйлс, бүйлс зэрэг сөөг, сөөгөнцөр ургадаг. 160 гаруй зүйлийн ургамал ургадгаас эмийн болон хүнсний ашигт ургамал 30-аад хувийг эзлэх бөгөөд эртний үлдвэр ургамлуудын зүйлээр баялаг. Халиун буга, бор гөрөөс болон саарал чоно, дорго, цагаан зээр, талын үнэг, хярс үнэг, бор туулай зэрэг тал хээрийн амьтад амьдардаг. Мөн талын бүргэд, талын сар, идлэг шонхор зэрэг өвөлждөг шувуудаас гадна нүүдлийн болон эргийн усны шувууд элбэг тохиолдоно.
- Тосонхулстайн БНГ-т Монгол Дагуурын хэв шинжийг хадгалсан ургамал, амьтны аймгийн зүйлийн бүрдлээр баялаг, гадагш урсгалгүй олон тооны битүү хонхор, хонхорууд нь хур борооны болон гадаргуугийн урсгалаар тэжээгдэн нуур тойрмууд үүсгэх учир усны шувууд түр хугацаагаар буудаллан саатах, өндөглөх зэрэгт тохиромжтой. Тиймээс биологийн төрөл зүйлийн хамгаалалтын хувьд улс орны төдийгүй бүс нутаг, дэлхийн хэмжээнд ач холбогдолтой нутаг юм.
- Засаг захиргааны 4 нэгжтэй



2. Хүн амын тоо, яс үндэс, соёл, уламжлал, ёс заншил:

- 2016 оны тооллогоор 530 өрх, 1709 хүн амтай, Хүн амын олонхи нь халх ястан, цөөн тооны бага ястанууд амьдардаг.
- Наадам

3. Сумын брэнд бүтээгдэхүүн, түүний онцлог:

4. Малын тоо, ангилал, сүүлийн 5 жилээр:

№	Он	Малын тоо (төрлөөр)					Нийт дүн
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
1	2012	347	8386	6296	45933	28532	89494
2	2013	319	9472	7202	48579	30436	96008
3	2014	303	11101	8741	53883	36629	110657
4	2015	342	13701	10469	60943	39338	124793
5	2016	364	15997	12304	70214	48445	147325



5. Амьтан, ургамлын аймаг, төрөл зүйл, ангилал:

Ургамал: Баян-Овоо сум нь Ботаник-газарзүйн мужлалаар Дундад Халхын хээрийн тойрогт багтдаг бөгөөд Монгол Дагуур, Дорнод Монголын тойрогтой залгаа оршдог тул ургамлан нөмрөгт Манжуур, Монгол Дагуур, Дорнод Монголын элементүүд түгээмэл тархдаг. Тус сум нь ургамлын аймгийн ангиллаар Евразийн хээрийн их мужийн, Монголын хээрийн мужийн, Монголын Дорнод хээрийн дэд мужид хамаарагддаг. Энд уулын хээрийн болон хээрийн бүлгэмдэлтэй бөгөөд нам уулс, өндөрлөг толгодын ар хажуугийн дээд хэсгээр нугажуу хээрийн улалж-алаг өвс-үетэнт бүлгэмдэл бүхий сөөгөн ширэнгэ зонхилох

бөгөөд Түмэнцогт уулын ар хажууд хус, улиангаран төгөл тохиолдоно. Харин толгодын энгэр, хад чулуутай эгц хажуугаар үетэн- алаг өвст бүрхэвч бүхий сөөгөн бүйлст бүлгэмдэл зонхилно. Хадтай намхан уулс, толгой болон тэдгээрийн хооронд орших нарийн ам, хөндийд уулын хээрийн болон нугын ургамалшилтай, тэгш өндөрлөг, нам толгодод хялгана-үетэн, хялгана-зүр өвст, үетэн-алаг өвст хээртэй. Хар-Ямаатын БНГ-ын уулсын хажуу, энгэр, араар гүйлс, буйлс, чаргай, хөндий хоолойгоор хайлаас, монос армаг тармаг ургасан байдаг. Хар Ямаатын БНГ нь 160 зүйлийн ургамалтайгаас эмийн болон хүнсний ашигт ургамал 30-аад хувийг эзэлнэ. Мөн нэн ховорт тооцогдох 10 гаруй зүйл ургамалтай. Улиангар, бор хус, яшил, яргай, гандигар, хайлаас зэргээс бүрдсэн төгөл 150 гаруй га талбайг эзэлнэ. Эмийн болон ховор ургамлаас өргөст сарнай (*Rosa acicularis*), юлдэн тарваган шийр (*Thermopsis lanceolata*), гандигар, монгол догар, алтан гагнуур, манчин, тэхийн шээг, таван салаа, нарийн сараан, туйпланцар, бамбай, дэрвээн хазаар өвс (*Cleastogenos squarrosa*), Ленийн ботууль (*Festuca lenensis*), сибирь хялгана (*Stipa baicalensis*), зургаадай зогдор чоно (*Clenatis hexapetala*), удвал навчит тавилгана (*Spioasa ciqui-lejifolia*), сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), ацан цахилдаг (*Iris dichotoma*), монгол бүрэлгэнэ зэргээс гадна үрэл, мойл, долоогоно зэрэг жимс жимсгэнэ ургадаг.





Амьтан: Тус сум нь амьтны аймгийн төрөл зүйлийн хувьд харьцангуй цөөн зүйлтэй, хуурай хээрийн болон уулын хээрийн амьтад тархсан байдаг бөгөөд тал хээрийн бүсийн хөхтөн амьтны гол төлөөлөгч болох цагаан зээрийн тархац нутгийн нэг. Мөн Монгол орны дорнод хэсгийн нүүдлийн ихэнх зүйл шувууд дайран өнгөрдөг нутаг юм. Агнуурын ач холбогдол бүхий амьтад төдийлөн их тархаагүй боловч цагаан зээр, саарал чоно, шар үнэг, хярс үнэг зэрэг амьтад тархсан байдаг.

Хөхтөн:

Умрын ой тайгын зүйлүүд (халиун буга, бор гөрөөс, чандага, бор туулай г.м), Төв Азийн тал хээрийн зүйлүүд (бор туулай, монгол тарвага, цайвар үлийч, хярс үнэг, мануул мий) өргөн тархаж харилцан нэвтрэлцсэн нутаг юм. Түүнээс гадна Дорно Азийн амьтны аймгийн олон төлөөлөгчид (дагуур номин, дагуур зараа, дагуур зурам) байдгаараа онцлогтой. Эндхийн хөхтнөөс Монгол Улсын Улаан номонд 1 зүйл (дагуур зараа), Ховор амьтны жагсаалтанд 1 зүйл (халиун буга), Олон улсын Улаан номонд 1 зүйл (саарал чоно), Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн II хавсралтад 2 зүйл (саарал чоно, мануул) бүртгэгджээ. Хамгийн өргөн тархсан амьтан бол туурайтнаас бор гөрөөс, цагаан зээр байна. Мөн аргаль гүйдлээр орж ирсэн тохиолдол бий. Мэрэгчдээс дагуур огодой, монгол тарвага, орог зусаг, монгол чичүүл, дагуур зурам, үлийн цагаан оготно зэрэг амьтад тархсан ба махчдаас саарал чоно, шар үнэг, хярс үнэг байдаг.

Шувуу: Махчин шувуудаас шилийн сар, идлэг шонхор, зээрд шонхор, начин шонхор, тарважи, цармын бүргэд, тас, шар шувуу, хотны бүгээхэй зэргийг нэрлэж болно. Мөн ангир, анхидал, байгалийн нугас, бор нугас, бор галуу, тураг гогой, гангар хун, өвөгт тогоруу, цэн тогоруу, хавтгаалж, үхэр цахлай, хөх дэглий, хар өрөвтас зэрэг ус намгийн шувуудаас гадна, монгол болжмор, хадны тагтаа, хар хэрээ, дагуурын ятуу, шаазгай улаан хошуут, өвөөлж, их хөх бух, бор шувуу, хөх түрүүт хөмрөг, хөх цэгцгий гээд олон зүйлийн бусад шувууд тархсан байдаг. Эдгээр шувуудаас зарим нь өндөглөн зусдаг бол зарим нь БНГ-т суурин байршдаг ажээ.

Хоёр нутагтан, мөлхөгчид:

Хар Ямаатын БНГ, түүний орчимд 2 зүйлийн 2 нутагтан, 3 зүйлийн мөлхөгчид бүртгэгдсэн байна. Монгол бах (*Bufo raddei*), Шивэр мэлхий (*Rana amurensis*), монгол гүрвэл (*Eremias argus*), рашааны могой (*Elaphe dione*), зэрэг амьтад багтана. Зун цагт голын дагуу монгол бах харьцангуй элбэг тааралдана.

Загас:

Загасны зүйлийн бүрдлийн хувьд Хэрлэнгийн ай савд багтдаг. Энд Амарын нүцгэн жараахай (*Phoxinus phoxinus*), гүрц (*Gobio gobio*) Амарын сугас (*Leuciscus waleckii*), улаан живэрт (*Pseudaspius leptocephalus*), Амарын цулбуурт (*Parasilurus asotus*), гутаарь (*Lota lota*) зэрэг зүйлийн загас тархсан байна



6. Түүхийн дурсгалт газрууд: Баян-Овоо суманд Эртний хүн амьдарч байсан ул мөр бүхий газар 1, тахил тайлгын байгууламж 20, барилга, архитектурын дурсгал 5, чулуун зэвсгийн дурсгалт газар 3, хөшөө дурсгал 6, хадны зураг, бичгийн дурсгал 1 бүртгэгдсэн байна.

- Гүрмийн нуурын чулуун зэвсгийн дурсгалт газар



2016 онд ОНХ-ийн сангийн 7.5 сая төгрөгийн хөрөнгөөр түүх соёлын дурсгалт 14 газрыг тэмдэгжүүлсэн.




Гүрмийн нуурын чулуун зэвсгийн дурсгал

Гүрмийн нуур нь эмчилгээний чанараараа Аваргатосон нууртай ижил, Гүрмийн нуурыг 2005 онд аймгийн тусгай хамгаалалтад авсан бөгөөд сумын төвөөс зүүн хойш 7-8 км-т д.т.д 918м-ийн өндөрт оршдог эрдэст нуур юм. Нуурын урт 3.1 км, өргөн 2.66 км, эргийн шугамын урт 8.8 км, хамгийн их гүн 4.8 м, урд хэсгээрээ 5 м өндөр элсэн хаялагатай. Нуурын баруун хойд талд орших Дэлгэр-Овоо уулын энгэр бэлээр эртний булш, хиргисүүр, тахилын онгон, нуурын зүүн эргээр чулуун зэвсгийн үеийн дурсгалууд тохиолдоно. Нуур нь 3 төрлийн шавар, 3 төрлийн усны шавьжтай. Эдгээрийг эрт дээр үеэс үе мөчний өвчин, харшлын өвчин, артерын цусны даралтын өвчний үед хэрэглэж ирсэн. Сүүлийн жилүүдэд ирж эмчлүүлэх, аялагчдын тоо нэмэгдсээр байна.



Сүмбэр багийн нутагт орших Ханзат хотын туурь.


2017 онд МУ-ын Түүхийн хүрээлэнгээс түүхэн он цагийг тодруулах зорилгоор судалгааны ажил хийгдэн, 2018 онд малтлагын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.



Монгол орны бараг бүх аймагт байдаг хөшөө дурсгал 3-4 м өндөр гозгор нарийн хөшөө чулууг Чингисийн морины уяа, Чингисийн гүүн зэлний гадас мэтээр домоглон нэрлэж иржээ. Хөшөөний ард талд эртний хятад ханз бичиг, дүрстэй.



Урьд нэгэн цагт өглөөгүүр энгэрийнх нь худаг дээр мал услахаар хүмүүс иржээ. Тэгтэл адууны дэл сүүлний ганц ширхэг хялгасаар есөн хэдгэнийн хөлөөр нь холбоод орхичихсон байсан гэнэ. Хүмүүс хачин юм хэн ингэдэг байна аа гэж гайхацгаажээ. Үүнийг хийсэн хүмүүс энэ ууланд байгаа гэж нутгийн иргэд нум саадгаа агсаж, уулийг бүслэсэн байна. Гэтэл ууланд их л холоос ирж, ядарч зүдэрсэн 9 хүн байж. Эдгээр хүмүүс нь Сангас, Төвдийн иргэд байсан бөгөөд нутгийн ардууд орон гэр, хоол хүнсээр туслаж байсан гэдэг. Ингээд тус уулыг 9 хүн хэмээн нэрлэсэн түүхтэй.



Дэлгэрхаан багийн нутагт орших сумын төвөөс 40-өөд км-т Загийн амны Бичигт хаданд нь 1 мөр Монгол, 2 мөр Төвд үсгээр бичсэн бичээс байдаг. Монгол бичгээр Их Монгол улс гэж сийлсэн бөгөөд Төвд үсгээр “Ум ма ни бодь ми хум” гэж бичсэн байдаг.

7. Байгалийн баялаг, ашигт малтмалын орд газар:

Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын илрэл 25 тэмдэглэгдсэн байдгаас хайлуур жоншны далд уурхай 1 ажиллаж байна.

Тус суманд Номхон далайн ай савд багтах уулын түргэн урсгалт Хэрлэн гол, Сүмбэр, Наанги, Чойчин зэрэг нуурууд нь хужир шүү, давсаар баялаг, зүүн бүсийн сумдыг хужир шүүгээр хангаж байна.

8. Жижиг, дунд үйлдвэрлэл:

II багийн иргэн Б.Оюунболор нь “Арвижих” талх нарийн боовны цехийг байгуулан орон нутгийнхаа иргэдийг өдөр бүр шинэ, стандартын шаардлага хангасан талх нарийн боов, гурил гурилан бүтээгдэхүүнээр хангаж байна. Захиалгаар төрөл бүрийн бялууг хийж хэрэглэгчдийг шинэ амт чанар сайтай бүтээгдэхүүнээр хангаж байна.



Чингис хотноо 2017 оны 09 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Намрын баяр” үзэсгэлэн худалдаа, 9 дүгээр сарын 21-22 өдрүүдэд Хэнтий аймгийн Засаг даргын ивээл дор зохиогдсон зүүн бүсийн “Нөхөрлөл хөгжил-2017” наадам, 10 дугаар сарын 3-ны өдөр Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд зохион байгуулагдсан “Баялаг бүтээгчдийн туршлага солилцох уулзалт үзэсгэлэн” худалдаанд амжилттай оролцсон.

Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд оролцсоноор өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилах, өрсөлдөх чадварыг бий болгох, туршлага солилцох зэрэг олон төрлийн мэдлэг чадвартай болсон байна.

2018 онд хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулан сургууль цэцэрлэг дотуур байрны хүүхдүүдийг гурил гурилан бүтээгдэхүүнээр хангах тендерт оролцох зорилго тавьж өөрийн ур чадвар, бүтээгдэхүүний төрлийг улам нэмэгдүүлэн ажиллаж байна.



Төслийн санхүүжилтээс 6 сая төгрөгөөр хөргөгч хөргүүр, зуурагч, мексир, шарх шүүгээ бусад тоног төхөөрөмжүүдийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.



II багийн иргэн С.Наранбаатар нь 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр БНХАУ-ын эрээн хотоос универсал трактор худалдан авлаа. Орон нутгийн иргэд малчид болон зэргэлдээх сумын малчид өвлийн цагт Сүмбэрийн шүүг гараар ухаж авдаг байсан нь маш хүндрэлтэй асуудлын нэг байсан. Сум орон нутгийн хэмжээнд универсал трактортой болсноор энэ асуудлыг бүрэн шийдвэрлэсэн болно. Мөн орон нутгийн татварын орлого нэмэгдэж шинэ ажлын байртай болох боломж бүрдлээ.



9. Сумын хөгжлийн хэтийн төлөв:

Монгол Телевизийн “Эргэх 4 цаг” нэвтрүүлэгт Уран сийлбэрч Ж.Раяаг оролцуулан ярилцлага хийж, хийсэн уран бүтээлийг ард иргэдэд олон нийтийн телевизээр сурталчлан таниулав.

Тамганы хайрцаг 2, ээрүүл 2, бэлэг дурсгалын сувнер эмээл 2,хайрцаг 1

